



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙН ЗАХИРЛЫН  
ТУШААЛ

2025 оны 04 сарын 22нд

Дугаар А135

Арвайхээр сум

Дэд хөтөлбөр батлах тухай

Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх заалт, 19 дүгээр зүйл, 27 дугаар зүйлийн 27.5.1 дэх заалт, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, 15 дугаар заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Суралцагчдын өргөтгөсөн чадавх, хөдөлмөрийн соёл, дадлага хичээлийн чанар үр дүнг сайжруулан түншлэлийн интеграцийг хөгжүүлж, тогтвортой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх "Суралцагчдыг хөдөлмөрт бэлтгэх дэд хөтөлбөр"-ийг нэгдүгээр хавсралт, "Элсэлт зохион байгуулах үйл ажиллагааны дэд хөтөлбөр"-ийг хоёрдугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг гаргаж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Сургалтын албаны менежер (С.Уртнасан)-т, дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд жил тутам өөрийн үнэлгээ хийж, захирлын зөвлөлд танилцуулж ажиллахыг Чанарын баталгаажилт, дотоод хяналтын менежер(Б.Хуягмаа)-т тус тус үүрэг болгосугай.

3. Дэд хөтөлбөрүүдийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийн төлөвлөлтийг үнэн зөв төлөвлөж ажиллахыг Сургалтын албаны менежер (С.Уртнасан)-т, шаардагдах төсвийг төсвийн зохих зүйл ангиас зарцуулахыг Ерөнхий нягтлан болоч(С.Хандсүрэн)-д даалгасугай.

ЗАХИРАЛ



С.САНЧИР

## **ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙН "СУРАЛЦАГЧДЫГ ХӨДӨЛМӨРТ БЭЛТГЭХ" ДЭД ХӨТӨЛБӨР**

### **Нэг. Үндэслэл**

Өвөрхангай аймаг дахь Политехник коллежийн суралцагчдад асуудлыг шийдэл болгож, ажил хайгч биш, ажил бий болгогч сэтгэлгээтэй бүтээлч энтрепренеруудыг бэлтгэх, сургалтын агуулга, дадлага, үйлдвэрлэлийн хэрэгслүүдийг хооронд уялдуулж, ирээдүйд ажлын орчинд илүү уян хатан, мэргэжлийн ур чадвар эзэмших, төгсөгчдийн тогтвортой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх үйл ажиллагааг зохион байгуулна.

Тус дэд хөтөлбөр нь "Боловсролын ерөнхий хууль", "Мэргэжлийн болон Техникийн боловсрол сургалтын тухай хууль", "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль", "Инновацийн тухай хууль", "Монгол Улсын Засгийн Газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр", "Алсын хараа-2050", "Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого", "Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал -2030", "Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр", Өвөрхангай аймаг дахь Политехник коллежийн "Стратеги төлөвлөгөө", ажил олгогчдын сэтгэл ханамжийн судалгааны үр дүнг үндэслэл болгов.

Энэхүү дэд хөтөлбөрт техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын суралцагчид суралцах, ажиллах, амьдрахад шаардагдах мэдлэг, ур чадвар, харилцаа хандлага, шинэ санаа, инноваци бий болгох, төгсөгчдөд гарааны бизнесийг дэмжин туслах, хөдөлмөрийн зах зээлд өрсөлдөх чадвартай ажилтан бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх зэрэгт чухал ач холбогдолтой асуудлыг тусгана.

Монгол улсын хөгжлийн урт хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан төсөл, хөтөлбөр, бүтээн байгуулалт, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, ажил олгогчийн шаардлагад нийцсэн мэргэжилтэй ажилтанг бэлтгэж, төгсөгчдийг ажлын байртай төгсөхөд тус хөтөлбөр хэрэгжих хэрэгцээ шаардлага үүсч байна.

### **Хоёр. Дэд хөтөлбөрийн зорилго**

2.1. Өвөрхангай аймаг дахь Политехник коллежийн суралцагчдын өргөтгөсөн чадавх, хөдөлмөрийн соёл, дадлага хичээлийн чанар үр дүнг сайжруулан түншлэлийн интеграцийг хөгжүүлж, тогтвортой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд хөтөлбөрийн зорилго оршино.

### **Гурав. Дэд хөтөлбөрийн зорилт**

3.1 Суралцагчдын зөөлөн ур чадварыг хөгжүүлж, хөдөлмөрийн соёлыг төлөвшүүлнэ.

3.2 Дадлага хичээлийн чанар үр дүнг сайжруулан түншлэлийн интеграцийг хөгжүүлнэ.

3.3 Суралцагчдын тогтвортой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.



### **Дөрөв. Дэд хөтөлбөрийн зарчим**

- 4.1. Монгол Улсын хуулиуд болон орон нутгийг хөгжүүлэх үндсэн чиглэл хөтөлбөртэй нийцсэн байх;
- 4.2. Суралцагчдад ээлтэй байх;
- 4.3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь нээлттэй, хүртээмжтэй, уян хатан, чанартай байх;
- 4.4. Суралцагчдын шинэ санаа, инновацийг дэмжиж хөгжүүлсэн байх;
- 4.5. Сургалтын байгууллагын сурган хүмүүжүүлэгч болон багш, нийгмийн түншлэл, ажил олгогчдын хамтын ажиллагааг хангахад чиглэсэн байх;

### **Тав. Дэд хөтөлбөрийн хамрах хүрээ**

- 5.1. Хөтөлбөрийг 2025-2028 оныг дуустал хэрэгжүүлнэ.
- 5.2. Өвөрхангай аймаг дахь Политехник коллежийн суралцагчид

### **Зургаа. Дэд хөтөлбөрийн хэрэгжүүлэх үйл ажиллагаа**

- 6.1 Суралцагчдын зөөлөн ур чадварыг хөгжүүлж, хөдөлмөрийн соёлыг төлөвшүүлнэ зорилтын хүрээнд
  - 6.1.1 "21 дүгээр зууны Soft skills" сургалтыг жилд 3 удаа зохион байгуулах;
  - 6.1.2 Суралцагчдад дутагдалтай байгаа зөөлөн ур чадварын талаарх судалгаа хийх, мэдээллийн сан бий болгох;
  - 6.1.3 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аян жилд нэг удаа зохион байгуулах;
- 6.2 Дадлага хичээлийн чанар үр дүнг сайжруулан түншлэлийн интеграцийг хөгжүүлнэ зорилтын хүрээнд
  - 6.2.1 Жилд сургууль дээрх дадлага хичээлийн 4 танхим засварлах, гар багаж хэрэгслийг нэмэгдүүлэх;
  - 6.2.2 Ажил олгогч, мэргэжлийн багш нарын оролцоотойгоор үйлдвэрлэлийн дадлагын 3 талт гэрээ, удирдамжийг шинэчлэх, баталгаажуулах, хэрэгжүүлэх, хянах;
  - 6.2.3 Үйлдвэрлэлийн дадлагын дэвтрийг тусгай хэрэгцээт суралцагчийн онцлогт тохируулан өөрчлөлт оруулах;
  - 6.2.4 Суралцагчдын инновац шингэсэн бүтээлийг түгээн дэлгэрүүлэх, сургуулийн брэнд бүтээгдэхүүн бий болгох;
  - 6.2.5 Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй бүтээн байгуулалтын ажлууд, хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүдэд суралцагчдыг хамруулж, дадлагуулах;
  - 6.2.6 Ажил олгогч, түншлэгч байгууллагын оролцоотойгоор үйлдвэрлэлийн дадлагад интеграци хийх;
  - 6.2.7 Ажил олгогч, сургалтын байгууллага, ХХҮГазрын хамтын үйл ажиллагааны түншлэл хоорондын интеграцийг турших;
  - 6.2.8 Хосмог сургалтыг турших;
  - 6.2.9 Дадлага удирдаж буй инженер, техникийн ажилтан, үйлдвэр цехийн мастер, суралцагчдаас сэтгэл ханамжийн судалгааг тогтмол авч, үр дүнд үндэслэн олон талт үйл ажиллагааг зохион байгуулах;

6.2.10 Ажил олгогч, мэргэжлийн холбоо, мэргэжлийн зөвлөлийн хамтын ажиллагааг тасралтгүй сайжруулах;

6.2.11 Мэргэжлийн багш нарыг тасралтгүй хөгжүүлэх, шинэ техник, технологи, үйл ажиллагаатай танилцан сургалтад нэвтрүүлэх "Багш инженер солилцоо" үйл ажиллагаа зохион байгуулах;

6.2.12 Үнэлээч бэлтгэх сургалтад ажил олгогчдыг хамруулах;

6.2.13 Үйлдвэрлэлийн дадлага хичээлийн үр дүнгээр жилд 10 "Шилдэг суралцагч" шалгаруулан, урамшуулж, алдаршуулах;

6.2.14 Шилдэг түншлэгч байгууллагыг шалгаруулан, урамшуулж, алдаршуулах;

6.3 Суралцагчдын тогтвортой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ зорилтын хүрээнд

6.3.1 Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх сургалтыг жилд хоёр удаа ХХҮГазартай хамтран зохион байгуулах;

6.3.2 Суралцагчдад хөдөлмөр эрхлэлт, ажлын байрыг дэмжих төсөл хөтөлбөрүүдийн талаарх мэдээлэл хүргэх, төсөл боловсруулах зөвлөгөө өгөх;

6.3.3 Мэргэжил тус бүрээр үе шаттайгаар суралцагчдын хоршоо байгуулах;

6.3.4 Түншлэгч байгууллагуудын мэдээллийн санг шинэчлэх, хамтын ажиллагааны гэрээг шинээр байгуулж, түншлэгчдийн оролцоог нийгмийн түншлэлийн бүхий л түвшинд хангаж, үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан ажиллах;

6.3.5 Төгсөлт бүрийн дараах 3 болон 6 сарын мөшгөх судалгаа зохион байгуулж, хөдөлмөр эрхлээгүй шалтгаан нөхцлийг тодорхойлж, үр дүнг дараагийн төлөвлөлтөд ашиглах;

6.3.6 Хөдөлмөр эрхлээгүй төгсөгчдийг ХХҮГазарт идэвхитэй ажил хайгчаар бүртгүүлж, сургалт мэдээллээр ханган ажилд зуучлах;

6.3.7 Хөдөлмөрийн яармаг жилд нэг удаа зохион байгуулах;

6.3.8 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх санхүүгийн дэмжлэг, бичил зээлд төгсөгчдийг хамруулах, мэдээлэл хүргэх

### **Долоо. Дэд хөтөлбөрийн хүрэх үр дүн**

7.1 Сургууль дээрх дадлагын чанарт ахиц гарна.

7.2 Суралцагчид бүтээлч сэтгэлгээ, багаар ажиллах чадварт суралцахаас гадна суралцагчийн өөрийн санаачилга бодитоор хэрэгжих боломж нэмэгдсэн байна.

7.3 Суралцагчдын мэдлэг, ур чадвар, хандлага сайжирсан байна.

7.4 Суралцагчдад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дадал эзэмшүүлж, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах чадварт суралцуулсан байна.

7.5 Ажил олгогчдын сэтгэлд нийцсэн мэргэжлийн ур чадвартай болсон байна.

7.6 Хөдөлмөр эрхлэхэд бэлтгэгдсэн байна.

7.7 Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт жилд 85% хүрсэн байна.

7.8 Төгсөгчдийн хөдөлмөрийн зах зээл дэх үнэ цэнэ нэмэгдсэн байна.

7.9 Нийгмийн түншлэлийн хүрээ өргөжиж, хамтын ажиллагаа сайжирна.

### **Найм. Дэд хөтөлбөрийн санхүүжилт**

8.1. Дэд хөтөлбөрийн санхүүжилт дараах эх үүсвэрээс бүрдэнэ.

8.1.1. Улсын төсөв

8.1.2. Бусад эх үүсвэр



**Ес. Дэд хөтөлбөрийн удирдлага зохион байгуулалт**

9.1. Дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд Чанарын баталгаажилтын алба хяналт үнэлгээ хийх,

зөвлөн туслах үүргийг хүлээнэ. Үүнд:

9.1.1. Дэд хөтөлбөрийн хэрэгжүүлэх төлөвлөгөөг хичээлийн жилээр төлөвлөн нийгмийн түншлэл, үйлдвэрлэлийн сургалт хариуцсан арга зүйч нар, нийгмийн ажилтан, мэргэжлийн багш нартай хамтран боловсруулж хэрэгжилтийг хангаж ажиллана.

9.1.2. Дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд хагас жилд 1 удаа хяналт шинжилгээ, үнэлгээ

хийнэ.

9.1.3. Хяналт, шинжилгээ, үнэлгээний үр дүнг жил тутамд хэлэлцүүлэн, дүгнэнэ.

---oOo---

**Арав. Дэд хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин**

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин				Хариуцах эзэн
			2025 он	2026он	2027 он	2028 он	
<b>Зорилт 1: Суралцагчдын зөөлөн ур чадварыг хөгжүүлж, хөдөлмөрийн соёлыг төлөвшүүлнэ!</b>							
1	"21 дүгээр зууны Soft skills" сургалт зохион байгуулах	Суралцагчид өөрийгөө таньж мэдэх, ухамсарлах, сэтгэл хөдлөлөө тодорхойлох, стрессийг удирдах, цагаа зөв зохицуулах, төлөвлөх, өөрийн давуу тал, хүчийг таньж мэдсэн байна.	Арга хэмжээ: 1	Арга хэмжээ: 2	Арга хэмжээ: 2	Арга хэмжээ: 2	Насан туршийн боловсролын төв, Энтрепренершипд суурилсан хувь хүний ур чадварыг хөгжүүлэх сургалтын сургагч багш: С.Отгонбаяр, Р.Янжинсүрэн, Б.Ганбаатар, Л.Гандолгор, Т.Цэрэнбал
2		Харилцааны болон хувь хүний биеэ авч явах соёл, бусадтай зөв харьцах, ойлголцох, анхааралтай сонсох, ярих, өөрийн санаа бодлоо илэрхийлэх чадварыг эзэмшсэн байна.	Арга хэмжээ: 1	Арга хэмжээ: 1	Арга хэмжээ: 1	Арга хэмжээ: 1	
3		Аливаа учир шалтгааныг эргэцүүлэх, ёс зүйтэй шийдвэр гаргах, өөрийн үйл хэргийг эргэж дүгнэх, бэрхшээлтэй тулгарсан үед түүнийг даван туулах чадваруудыг эзэмшсэн байна.	Арга хэмжээ: 1	Арга хэмжээ: 1	Арга хэмжээ: 1	Арга хэмжээ: 1	
4	Суралцагчдад дутагдалтай байгаа зөөлөн ур чадварын талаарх судалгаа хийх, мэдээллийн сан бий болгох	Үйлдвэрлэлийн дадлагын дэвтэрт инженер техникийн ажилтны үнэлгээнд үндэслэн зөөлөн ур чадварыг хөгжүүлэх саналд анализ дүгнэлтийг хийж үр дүнг нэгтгэж мэргэжлийн багш нарыг мэдээллээр хангасан байна.	Арга хэмжээ: 1	Арга хэмжээ: 1	Арга хэмжээ: 1	Арга хэмжээ: 1	Мэргэжлийн багш нар, НТҮСХАрга зүйч нар
5			Арга хэмжээ:	Арга хэмжээ:	Арга хэмжээ:	Арга хэмжээ:	



		Ахицыг тодорхойлж үр дүнг нэгтгэж мэргэжил тус бүрээр судалгааны сан бий болгосон байна.	1	1	1	1	Мэргэжлийн багш нар, НТҮСХАрга зүйч нар
			Хэрэгжилт: 100%	Хэрэгжилт: 100%	Хэрэгжилт: 100%	Хэрэгжилт: 100%	
6	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аян зохион байгуулах	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангах, ажлын байранд учирч болзошгүй эрсдэлээс өөрийгөө хамгаах чадварт суралцуулах замаар хөдөлмөрийн соёлыг төлөвшүүлнэ.	Арга хэмжээ: 1	Арга хэмжээ: 1	Арга хэмжээ: 1	Арга хэмжээ: 1	Мэргэжлийн багш нар, НТҮСХАрга зүйч нар
			Хэрэгжилт: 100%	Хэрэгжилт: 100%	Хэрэгжилт: 100%	Хэрэгжилт: 100%	
<b>Зорилт 2: Дадлага хичээлийн чанар үр дүнг сайжруулан түншлэлийн интеграцийг хөгжүүлнэ</b>							
1	Сургууль дээрх дадлага хичээлийн орчин, нөхцөлийг сайжруулах	Суралцагчдын сургууль дээрх дадлага хичээлийн хүрээнд анги танхим, дадлагын газруудын сургалтын орчныг сайжруулсан байна.	Арга хэмжээ: 4	Арга хэмжээ: 4	Арга хэмжээ: 4	Арга хэмжээ: 4	Мэргэжлийн багш нар, НТҮСХАрга зүйч нар
			Хэрэгжилт: 100%	Хэрэгжилт: 100%	Хэрэгжилт: 100%	Хэрэгжилт: 100%	
2	Сургууль дээрх дадлага хичээлийн орчин, нөхцөлийг сайжруулах	Дадлагын газрын гар багаж хэрэгслийн тоог нэмэгдүүлж сургууль дээрх дадлага хичээлийн үр дүнг нэмэгдүүлсэн байна.	Арга хэмжээ: 1	Арга хэмжээ: 1	Арга хэмжээ: 1	Арга хэмжээ: 1	Мэргэжлийн багш нар, НТҮСХАрга зүйч нар
			Хэрэгжилт: 100%	Хэрэгжилт: 100%	Хэрэгжилт: 100%	Хэрэгжилт: 100%	
3	Ажил олгогч, мэргэжлийн багш нарын оролцоотойгоор	Оролцогч талуудын ашиг сонирхолд нийцүүлэн мэргэжлийн холбоод, мэргэжлийн зөвлөлүүдийн оролцоотойгоор үйлдвэрлэлийн	Арга хэмжээ: 2	Арга хэмжээ: 2	Арга хэмжээ: 2	Арга хэмжээ: 2	Мэргэжлийн багш нар, НТҮСХАрга зүйч нар

	Үйлдвэрлэлийн дадлагын 3 талт гэрээ, удирдамжийг шинэчлэх, баталгаажуулах, хэрэгжүүлэх, хянах	дадлагын 3 талт гэрээг шинэчилж, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөтэй уялдуулан үйлдвэрлэлийн дадлагын удирдамж боловсруулж суралцагчдыг дадлагын байраар хангаж ажилласан байна.	Хэрэгжилт: 100%	Хэрэгжилт: 100%	Хэрэгжилт: 100%	Хэрэгжилт: 100%	
4	Үйлдвэрлэлийн дадлагын дэвтрийг тусгай хэрэгцээт суралцагчийн онцлогт тохируулан өөрчлөлт оруулах	Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын биеийн онцлогт тохирсон үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдтэй хамтран тэднийг үйлдвэрлэлийн дадлагад тэгш хамрагдах боломжийг бүрдүүлэн ажиллана.	Арга хэмжээ: 2	Арга хэмжээ: 2	Арга хэмжээ: 2	Арга хэмжээ: 2	Мэргэжлийн багш нар, НТҮСХАрга зүйч нар
			Хэрэгжилт: 100%	Хэрэгжилт: 100%	Хэрэгжилт: 100%	Хэрэгжилт: 100%	
5	Суралцагчдын инновац шингэсэн бүтээлийг түгээн дэлгэрүүлэх, сургуулийн брэнд бүтээгдэхүүн бий болгох	"Нэг суралцагч Нэг бүтээл", "Нэг анги Нэг бүтээл" арга хэмжээг тогтмол зохион байгуулж, сургуулийн брэнд бүтээгдэхүүний тоог нэмэгдүүлсэн байна.	Арга хэмжээ: 2	Арга хэмжээ: 2	Арга хэмжээ: 2	Арга хэмжээ: 2	Мэргэжлийн багш нар, НТҮСХАрга зүйч нар
			Хэрэгжилт: 50%	Хэрэгжилт: 60%	Хэрэгжилт: 70%	Хэрэгжилт: 80%	
6	Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй бүтээн байгуулалтын ажлууд, хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүдэд суралцагчдыг хамруулж, дадлагажуулах	Аймаг орон нутагт хийгдэж буй бүтээн байгуулалтын ажлууд, төсөл хөтөлбөрүүдэд жилд 200-аас доошгүй суралцагчийг хамруулж, цалинтай дадлагажуулсан байна.	Арга хэмжээ: 1	Арга хэмжээ: 1	Арга хэмжээ: 1	Арга хэмжээ: 1	Мэргэжлийн багш нар, НТҮСХАрга зүйч нар
			Хэрэгжилт: 60%	Хэрэгжилт: 70%	Хэрэгжилт: 80%	Хэрэгжилт: 90%	



7	Ажил олгогч, түншлэгч байгууллагын оролцоотойгоор үйлдвэрлэлийн дадлагад интеграци хийх	Ажил олгогчийн захиалгын дагуу ажлын байран дээрх уялдаа холбоо бүхий мэргэжлийн ангийн суралцагчдыг тухайн аж ахуй нэгжид дадлагажуулан үйлдвэрийн ажлын бүтээмжийг нэмэгдүүлэхэд интеграци хийсэн байна.	Арга хэмжээ: 2	Арга хэмжээ: 2	Арга хэмжээ: 2	Арга хэмжээ: 2	НТҮСХАрга зүйч нар
			Хэрэгжилт: 100%	Хэрэгжилт: 100%	Хэрэгжилт: 100%	Хэрэгжилт: 100%	
8	Ажил олгогч, сургалтын байгууллага, ХХҮГазрын хамтын үйл ажиллагааны түншлэл хоорондын интеграцийг турших	Түншлэлийн үйл ажиллагаагаар дамжуулан 1-2 мэргэжлээр түншлэл хоорондын интеграцийг босоо хэлбэрээр хэрэгжүүлж ажилласан байна.	Арга хэмжээ: 1	Арга хэмжээ: 1	Арга хэмжээ: 1	НТҮСХАрга зүйч нар	
			Хэрэгжилт: 50%	Хэрэгжилт: 60%	Хэрэгжилт: 70%		
9	Хосмог сургалтыг турших	Төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлаж ур чадвартай мэргэжилтэй ажилтан бэлтгэх хосмог сургалтыг турших	Арга хэмжээ: 1	Арга хэмжээ: 1	Арга хэмжээ: 1	Сургалтын алба, Мэргэжлийн багш нар	
			Хэрэгжилт: 50%	Хэрэгжилт: 60%	Хэрэгжилт: 70%		
10	Дадлага удирдаж буй инженер, техникийн ажилтан, үйлдвэр цехийн мастер, суралцагчдаас сэтгэл ханамжийн судалгааг тогтмол авч, үр дүнд үндэслэн олон талт үйл ажиллагааг зохион байгуулах	Сэтгэл ханамжийн судалгаанд үндэслэн дадлагын чанар, үр дүнг нэмэгдүүлэх, суралцагчдын мэдлэг, ур чадвар, хандлагыг сайжруулах сургалтуудыг жилд 2-оос доошгүй удаа зохион байгуулсан байна.	Арга хэмжээ: 2	Арга хэмжээ: 2	Арга хэмжээ: 2	Арга хэмжээ: 2	НТҮСХАрга зүйч нар

			Хэрэгжилт: 100%	Хэрэгжилт: 100%	Хэрэгжилт: 100%	Хэрэгжилт: 100%	
11	Ажил олгогч, мэргэжлийн холбоо, мэргэжлийн зөвлөлийн хамтын ажиллагааг тасралтгүй сайжруулах	Ажил олгогчдын эрэлт хэрэгцээ, шалгуур шаардлагад нийцсэн мэргэжилтэй ажилтан бэлтгэхэд ажил олгогчдыг шууд ба шууд бус бусад хэлбэрүүдээр эргэх холбоог тасралтгүйгээр нэмэгдүүлж, үр дүнд тогтмол сайжруулалт хийнэ.	Арга хэмжээ: 1	Арга хэмжээ: 1	Арга хэмжээ: 1	Арга хэмжээ: 1	Мэргэжлийн багш нар, НТҮСХАрга зүйч нар
			Хэрэгжилт: 100%	Хэрэгжилт: 100%	Хэрэгжилт: 100%	Хэрэгжилт: 100%	
12	Мэргэжлийн багш нарыг тасралтгүй хөгжүүлэх, шинэ техник, технологи, үйл ажиллагаатай танилцан сургалтад нэвтрүүлэх "Багш инженер солилцоо" үйл ажиллагаа зохион байгуулах	Мэргэжлийн багш нар дадлага удирдах явцдаа шинэ техник, технологи, үйл ажиллагаатай танилцан сургалтад нэвтрүүлж, инновацыг бий болгож ажилласан байна.	Багшийн тоо: 10	Багшийн тоо: 10	Багшийн тоо: 10	Багшийн тоо: 10	Мэргэжлийн багш нар, НТҮСХАрга зүйч нар
			Хэрэгжилт: 100%	Хэрэгжилт: 100%	Хэрэгжилт: 100%	Хэрэгжилт: 100%	
13	Үнэлээч бэлтгэх сургалтад ажил олгогчдыг хамруулах	Мэргэжлийн боловсрол сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төвтэй хамтран үнэлээчийн сургалтад ажил олгогчдыг хамруулж үнэлээчдийн тоог нэмэгдүүлсэн байна.	Арга хэмжээ: 1	Арга хэмжээ: 1	Арга хэмжээ: 1	Арга хэмжээ: 1	Мэргэжлийн багш нар, НТҮСХАрга зүйч нар
			Хэрэгжилт: 100%	Хэрэгжилт: 100%	Хэрэгжилт: 100%	Хэрэгжилт: 100%	
14	"Шилдэг суралцагч" шалгаруулан, урамшуулж, алдаршуулах	Үйлдвэрлэлийн дадлага хичээлийн үр дүнгээр жилд 10 "Шилдэг суралцагч" шалгаруулан, урамшуулж, алдаршуулах	Арга хэмжээ: 1	Арга хэмжээ: 1	Арга хэмжээ: 1	Арга хэмжээ: 1	Мэргэжлийн багш нар, НТҮСХАрга зүйч нар
			Хэрэгжилт: 100%	Хэрэгжилт: 100%	Хэрэгжилт: 100%	Хэрэгжилт: 100%	
15	Шилдэг түншлэгч байгууллагыг	Жил бүр нийгмийн түншлэлийн хүрээнд идэвхтэй хамтран	Арга хэмжээ:	Арга хэмжээ:	Арга хэмжээ:	Арга хэмжээ:	

	шалгаруулан, урамшуулж, алдаршуулах	ажилласан шилдэг 1 түншлэгч байгууллагыг шалгаруулан урамшуулж, үйл ажиллагааг олон нийтэд сурталчилсан байна.	1 Хэрэгжилт: 100%	1 Хэрэгжилт: 100%	1 Хэрэгжилт: 100%	1 Хэрэгжилт: 100%	Мэргэжлийн багш нар, НТҮСХАрга зүйч нар
<b>Зорилт 3: Суралцагчдын тогтвортой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ</b>							
1	Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтыг Мэргэжлийн боловсрол сургалтын төгсөх ангийн суралцагчдад, Мэргэжлийн боловсрол сургалтын 5 чиглэлийн 33 мэргэжлийн танилцуулга, зөвлөгөөг ерөнхий боловсролын 9-р анги төгсөх суралцагчдыг хамруулан ажилласан байна.	Арга хэмжээ: 2  Хэрэгжилт: 100%	Арга хэмжээ: 2  Хэрэгжилт: 100%	Арга хэмжээ: 2  Хэрэгжилт: 100%	Арга хэмжээ: 2  Хэрэгжилт: 100%	Хөдөлмөр халамж үйлчилгээний газар НТҮСХАрга зүйч нар
2	Төгсөгчдөд хөдөлмөр эрхлэлт, ажлын байрыг дэмжих төсөл хөтөлбөрүүдийн талаарх сургалт зохион байгуулах	Төгсөгчдийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамруулсан байна. Төсөл боловсруулахад нь туслах, зөвлөгөө өгч, мэдээллээр хангасан байна.	Арга хэмжээ: 2  Хэрэгжилт: 100%	Арга хэмжээ: 2  Хэрэгжилт: 100%	Арга хэмжээ: 2  Хэрэгжилт: 100%	Арга хэмжээ: 2  Хэрэгжилт: 100%	НТҮСХАрга зүйч нар
3	Мэргэжил тус бүрээр үе шаттайгаар суралцагчдын хоршоо байгуулах	Суралцагчид онолын болон ур чадварын мэдлэгээ бодит ур чадвар болгон хөгжүүлж бизнес эрхлэх үйл ажиллагаанд суралцан хөдөлмөрийн зах зээлд бэлтгэгдсэн байна.	Арга хэмжээ: 1  Хэрэгжилт: 50%	Арга хэмжээ: 1  Хэрэгжилт: 70%	Арга хэмжээ: 2  Хэрэгжилт: 90%	Арга хэмжээ: 2  Хэрэгжилт: 100%	Мэргэжлийн багш нар НТҮСХАрга зүйч нар

4	Түншлэгч байгууллагуудын мэдээллийн санг шинэчлэх, хамтын ажиллагааны гэрээг шинээр байгуулж, түншлэгчдийн оролцоог нийгмийн түншлэлийн бүхий л түвшинд хангаж, үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан ажиллах	Мэргэжлийн холбоод, мэргэжлийн зөвлөлүүдийн үйл ажиллагаагаар дамжуулан түншлэгчдийн идэвх оролцоог нэмэгдүүлж, мэдээллийн санг шинэчилж ажилласан байна.	Арга хэмжээ: 1	Арга хэмжээ: 1	Арга хэмжээ: 1	Арга хэмжээ: 1	 НТҮСХАрга зүйч нар
			Хэрэгжилт: 100%	Хэрэгжилт: 100%	Хэрэгжилт: 100%	Хэрэгжилт: 100%	
5	Мөшгөх судалгаа хийх, үр дүнг дараагийн төлөвлөлтөд ашиглах	Төгсөлт бүрийн дараах 3 болон 6 сарын мөшгөх судалгаа зохион байгуулж, хөдөлмөр эрхлээгүй шалтгаан нөхцлийг тодорхойлж, үр дүнг дараагийн төлөвлөлтөд ашиглах;	Арга хэмжээ: 2	Арга хэмжээ: 2	Арга хэмжээ: 2	Арга хэмжээ: 2	НТҮСХАрга зүйч нар
			Хэрэгжилт: 100%	Хэрэгжилт: 100%	Хэрэгжилт: 100%	Хэрэгжилт: 100%	
6	Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, төгсөгчдийг ажилд зуучлах	Хөдөлмөр эрхлээгүй төгсөгчдийг ХХҮГазарт идэвхитэй ажил хайгчаар бүртгүүлж, сургалт мэдээллээр ханган ажилд зуучлах	Арга хэмжээ: 1	Арга хэмжээ: 1	Арга хэмжээ: 1	Арга хэмжээ: 1	НТҮСХАрга зүйч нар
			Хэрэгжилт: 100%	Хэрэгжилт: 100%	Хэрэгжилт: 100%	Хэрэгжилт: 100%	
7	Хөдөлмөрийн яармаг жилд нэг удаа зохион байгуулах	Төгсөгчдийн мөшгөх судалгаанд үндэслэн хөдөлмөр эрхлээгүй төгсөгчдийг мэдээллээр тасралтгүй ханган ажилд зуучлан хөдөлмөрийн яармаг зохион байгуулсан байна.	Арга хэмжээ: 1	Арга хэмжээ: 1	Арга хэмжээ: 1	Арга хэмжээ: 1	НТҮСХАрга зүйч нар

			Хэрэгжилт: 100%	Хэрэгжилт: 100%	Хэрэгжилт: 100%	Хэрэгжилт: 100%	
8	Төгсөгчдийг төсөл хөтөлбөрт хамруулах	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх санхүүгийн дэмжлэг, бичил зээлд төгсөгчдийг хамруулах, мэдээлэл хүргэх	Арга хэмжээ: 1	Арга хэмжээ: 1	Арга хэмжээ: 1	Арга хэмжээ: 1	НТҮСХАрга зүйн нар
			Хэрэгжилт: 100%	Хэрэгжилт: 100%	Хэрэгжилт: 100%	Хэрэгжилт: 100%	

--oOo--